

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/” төсөл арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх **“УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТРЫН БАРИЛГЫГ ХҮЧИТГЭН ЗАСВАРЛАХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ /УЛААНБААТАР/” БОЛОВСРУУЛАХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

2022 оны 10 сарын 26 ны өдөр

Дугаар 2022/493

Улаанбаатар хот

Нэг талаас Барилга хот байгуулалтын яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Эм Эс Эл” ХХК (цаашид “зөвлөх” гэх) харилцан тохиролцож 2022 оны дугаар сарын ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1-д тодорхойлсон Ажлын даалгаварт заасан болон бусад шаардагдах ажил үйлчилгээг (цаашид “үйлчилгээ” гэх) үзүүлэх үүрэгтэй.
2. Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
3. Захиалагч нь хэрэгжүүлэх **“Улсын драмын эрдмийн театрын барилгыг хүчитгэн засварлах ажлын зураг төсөл /Улаанбаатар/”** боловсруулах, зөвлөх үйлчилгээ-г (цаашид “ажил” гэх) **[120,000,000] /Нэг зуун хорин сая/** (цаашид “гэрээний үнэ” гэх) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв.
Үүнд:
Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
2022 онд санхүүжих дүн: **[62,600,000] /Жаран хоёр сая зургаан зуун мянга/**
Захиалагчийн хяналтын зардал / 1% / 1,200,000 /Нэг сая хоёр зуун мянга/
Захиалагчийн хяналт гүйцэтгэгч: **“Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ**
Гэрээт ажил дуусах хугацаа: 2022 оны 03 дугаар сарын 15 -ын өдөр.
4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;
Хавсралт №1 Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ;
Хавсралт №2 Тайлан гаргах хуваарь;
Хавсралт №3 Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарь;
Хавсралт №4 Гүйцэтгэлийн баталгаа
Гэрээ нь энд дурдсан зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.
5. Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
6. Зөвлөх нь үйлчилгээг мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд үнэнч шударгаар үзүүлнэ. Энэхүү гэрээний дагуу зөвлөхийн ажиллуулж буй аливаа ажилтан шаардлага хангаагүй гэж захиалагч үзсэн бол зөвлөх уг ажилтныг нэн даруй солино. Улсын драмын эрдмийн театрын барилгыг хүчитгэн засварлах ажлын зураг төсөл, төсвийг холбогдох хууль дүрэм, стандарт, онол арга зүй, үнэн бодит судалгаанд үндэслэсэн байх ба эдийн засгийн үр ашгийн бүх төрлийн тооцоо болон үр өгөөж, зардлын харьцаа, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт тооцоог тооцсон байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлагыг хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


С.МАГНАЙСУРЭН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА


Э.ГАНХҮҮ


БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ САНХҮҮЧ


С.ДОЛЖИНСУРЭН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.НЯМДОРЖ
"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ИЙН
ЗАХИРАЛ


Ц.АМАРСАНАА
"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ИЙН
ХОТ БАЙГУУЛАЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН
ИНСТИТУТИЙН ЭРХДЭГЧ


О.ОДБАЯР
"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ИЙН
ЗУРАГ ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА


Д.ЧИНЗОЛБОО

"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ИЙН
ЗУРАГ ТӨСЛИЙН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН


Ж.АМАРЖИН
Барилга, хот байгуулалтын яам

Хаяг: 15170 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын
талбай

Утас: 76003333 Факс: (976 11) 322904

e-mail: info@mcud.gov.mn

"Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ

Хаяг: 15170 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Их тойруу1,
Барилгын хөгжлийн төв


Утас: 11-320338, 11-320734

Факс: (976 11)320338


e-mail: info@barilga.gov.mn

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ЭМ ЭС ЭЛ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ


Г.Болормаа

"ЭМ ЭС ЭЛ" ХХК-ИЙН МЕНЕЖЕР


Б.Дорждагва

Хаяг: Улаанбаатар хот, БЗД, 18-р
хороо, ЮУ БИ тауэр 15-1503

Утас: 99101245, 99031447

e-mail: mssl.architects1@gmail.com

Регистер: 6021026

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

1.1 Нэр томъёоны тайлбар

- 1.1 Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
- (а) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.
 - (б) “Зөвлөх” гэж захиалагчтай байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа аливаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.
 - (в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.
 - (г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
 - € “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.
 - (д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Зөвлөхөд төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.
 - (е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ.
 - (ё) “Гишүүн” гэж түншлэл /консорциум/ холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ.
 - (ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Зөвлөхийн аль нэгийг, харин “Талууд” гэж хоёуланг нь хэлнэ.
 - (з) “Нөхөн төлөх зардал” гэж зөвлөхийн ажлын хөлснөөс бусад үйл ажиллагаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ.
 - (л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ.
 - (м) “Үйлчилгээ” гэж Хавсралт №1-т тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Зөвлөхийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.
 - (о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Зөвлөхтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
 - (ө) “Ажиллах хүчин” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Зөвлөхийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.

1.2 Гэрээнд хэрэглэгдэх хууль

Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.

- 1.3 Гэрээнд ашиглах хэл** Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.
- 1.4 Мэдэгдэл** Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.
- 1.5 Байршил** Үйлчилгээг, гэрээний хавсралт №1-т заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харьяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстой.
- 1.6 Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ** Зөвлөх нь түншлэл /консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.
- 1.7 Итгэмжлэгдсэн төлөөлөгч** Гэрээний дагуу захиалагч эсхүл зөвлөхийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.
- 1.8 Татвар, хураамж** Зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.
- 1.9 Авилгал болон залилан мэхлэх үйлдэл** Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч зөвлөх бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.

Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон зөвлөх нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ

- 2.1 Гэрээ хүчин төгөлдөр болох** Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ.
- 2.2 Үйлчилгээг эхлэх** Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.
- 2.3 Гэрээний хугацаа дуусгавар болох** ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хугацааны дараагаар энэхүү гэрээний хугацаа дуусгавар болно.
- 2.4 Гэрээний өөрчлөлт буюу засвар** Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл хугацааг өөрчилж болно.
- 2.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл**
- 2.5.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.
- 2.5.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Зөвлөх гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
- 2.6 Гэрээ цуцлах**
- 2.6.1 Захиалагч гэрээг цуцлах** Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй.
- (а) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй;
- (б) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа;

- (в) Зөвлөх нь тендерт оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авлигал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа;
- (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
- (д) Захиалагч өөрийн санаачилгаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол;
- (е) Зөвлөх ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрын ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй;

2.6.2 Зөвлөхийн санаачилгаар гэрээг цуцлах

Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд зөвлөх өөрийн санаачилгаар гэрээг цуцлах эрхтэй

- (а) захиалагч нь ГЕН-ийн 7 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүсээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг зөвлөхийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй
- (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
- (в) Захиалагч ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрын ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй;
- (г) Захиалагч гэрээний дагуу хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 45 хоногийн хугацаанд (эсхүл зөвлөхийн бичгээр зөвшөөрөн сунгасан хоногт багтаан) тухайн зөрчлийг арилгаагүй;

2.6.3 Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

ГЕН-ийн 2.9.1 болон 2.9.2 зүйлд заасны дагуу гэрээг цуцалсан үед захиалагч дараах төлбөрийг зөвлөхөд төлөх ёстой:

- (а) Гэрээг цуцлах өдрөөс өмнө зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу төлбөл зохих үйлчилгээний хөлс;
- (б) ГЕН-ийн 2.6.1-ийн (а)-гаас (в) хүртэлх, мөн (е) заалтын дагуу гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөвлөхийн ажилтнууд, тэдний хууль ёсны хамтран амьдрагч нарыг буцаах замын зардал зэрэг гэрээг цуцалсны улмаас үүсэх аливаа бодит зардлын нөхөн олговор;

3. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 Ерөнхий зүйл

3.1.1 Гүйцэтгэлийн чанар

Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материалын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.

Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.

3.2 Ашиг сонирхлын зөрчил

Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстой бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхлын зөрчилд орохоос зайлсхийх ёстой.

3.3 Нууцлал

Зөвлөх, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа нууц мэдээллийг ямар нэгэн хувь хүн, байгууллагад дамжуулах эрхгүй бөгөөд үйлчилгээний үр дүнд боловсруулсан зөвлөмжийг нийтэд нээлттэй болгох эрхгүй

3.4 Зөвлөхийн хариуцах даатгал

Зөвлөх нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзлын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.

3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа

Зөвлөх нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:

- (а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,
- (б) Хавсралт №3-т заасан ажилтны жагсаалтад ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.
- (в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа

3.6 Тайлагнах хуваарь

Зөвлөх нь Хавсралт №2 -т заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.

3.7 Зөвлөхийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь

Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.

- 3.8 Нягтлан бодох
бүртгэл,
Хяналт
шалгалт болон
Аудит** Зөвлөх нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

4. ЗӨВЛӨХИЙН АЖИЛТНУУД

- 4.1 Ажиллах
хүчний
тодорхойлол
т** Зөвлөхийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Хавсралт № 3-т тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтад багтаана.
- 4.2 Ажилтныг
халах буюу
солих**
- (а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Зөвлөхийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй тавина.
 - (б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрөхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстой.
 - (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсэж болох ямар нэгэн нэмэлт зардлыг зөвлөх нэхэмжлэх эрхгүй болно.

5. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 5.1 Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох** Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа хүрээнд засгийн газрын байгууллагуудад зөвшөөрөл хяналт хийх албан бичиг илгээх, танилцуулах, батлуулах хурал уулзалтыг зохион байгуулах, эдгээр байгууллагуудаас зөвшөөрөл авахад бүх талын хүчин чармайлт гарган дэмжиж ажиллана.
- 5.2 Гэрээнд хэрэглэх хуулинд татвар хураамжийн талаар орсон өөрчлөлт** Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуульд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Зөвлөхийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Зөвлөхөд төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б)-д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстой.
- 5.3 Захиалагчийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгө** Захиалагч нь үйлчилгээний зорилгоор ашиглуулахаар Хавсралт 3.3-д заасан үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг тогтоосон хугацаанд үнэ төлбөргүйгээр Зөвлөхөд гарган өгөх ёстой.

6. ЗӨВЛӨХӨД ТӨЛӨХ ТӨЛБӨР

- 6.1 Нийт төлбөр** Зөвлөхөд төлөх нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний хавсралт №1-т тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчилснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно.
- 6.2 Гэрээний үнэ** (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
(б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
- 6.3 Төлбөр хийх нөхцөл. Хуваарь** Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан зөвлөхийн дансанд хийнэ. ГТН-д өөрөөр заагаагүй бол, түүнд тогтоосон хугацаанд хүчинтэй байхаар тооцож, зөвлөхийн ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнтэй тэнцэх хэмжээгээр эхний төлбөрийг хийнэ. Энэхүү баталгааг Хавсралт №2-д заасан маягт,

эсхүл захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрсөн өөр маягтаар гарган ирүүлнэ.

ГТН-д заасан нөхцөл болзлыг хангасны дараа, зөвлөхөд төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстой.

**6.4 Хугацаа
хоцорсон
төлбөрийн
хүү**

Захиалагч нь ГТН-ийн 6.4-д тогтоосон төлбөр хийх хугацааг арван таван хоногоос (15) дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам ГТН-д тогтоосон хэмжээгээр зөвлөхөд хүү төлөх ёстой.

7. ШУДАРГА БАЙДАЛ

**7.1 Шударга
байдал**

Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биеийнхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгыг хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

**8.1 Маргааныг эв
зүйгээр
шийдвэрлэх**

Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтад ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө.

Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

**8.2 Маргааныг
шийдвэрлэх**

Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.

III. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН-ийн зүйлийн дугаар	Гэрээний ерөнхий нөхцөлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчилнө.
1.1(a)	Гэрээнд хэрэглэх хууль нь {Монгол Улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актууд}
1.2	<p>“Эхлэлийн тайлан” гэж дараах судалгаа, материалыг бүрдүүлсэн тухай тайланг хэлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Зургийн даалгаварт заасан хэмжилтийн иж бүрэн зураг• Одоогийн байдлын судалгаа <p>Зураг төслийг хангагч болон ашиглагч байгууллагуудтай зөвшилцөж захиалагч хүлээн зөвшөөрөхүйц тайлан ирүүлэх.</p> <p>“Дундын тайлан” гэж гэж дараах судалгаа, материалыг бүрдүүлсэн тухай тайланг хэлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Барилга архитектур• Халаалт, агаар сэлгэлт• Ус хангамж, ариутгах татуурга• Хүчит төхөөрөмж, дотоор гэрэлтүүлэг• Галын дохиолол, гал унтраах систем• Холбоо дохиоллын зэрэг засварын ажлын иж бүрэн ажлын зураг• Барилгыг хүчитгэн засварлах их засварын ажлын төсөв• Тайлбар бичиг <p>Зураг төслийг хангагч болон ашиглагч байгууллагуудтай зөвшилцөж захиалагч хүлээн зөвшөөрөхүйц тайлан ирүүлэх.</p> <p>“Эцсийн шатны тайлан”-д инженерийн шугам сүлжээний иж бүрэн зураг төсөл, төсөвт магадлал хийлгэн дүгнэлтийг баталгаажуулан ирүүлэх.</p> <p>Ажлын зураг төсөл, төсөв, бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1, хуулбар хувь 1 ширхэг хэвлэмэл болон тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө /CD-д хуулах /.</p>
1.3	Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.



1.4	<p>Захиалагч: Барилга, хот байгуулалтын яам</p> <p>Захиалагчийн хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай-3, Засгийн газрын XII дугаар байр</p> <p>Захиалагчийн хяналт гүйцэтгэгч: “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ</p> <p>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Их тойруу-1</p> <p>Утас: +976 76003333</p> <p>Факс: +976 322904</p> <p>Захиалагчийг төлөөлөн Барилгын Хөгжлийн Төв Мэргэжилтэнг томилон ажиллана</p>
2.1	Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр: 2022 оны сарын-ны өдөр
2.2	Ажил дуусгах хугацаа: 2023 оны 03 сарын 15-ны өдөр.
2.3	<p>Тайлант үеийн хугацааг хавсралт №2-т заасан тайлан гаргах хуваарийн дагуу мөрдөнө.</p> <ul style="list-style-type: none"> • Эхлэлийн тайлан- Гэрээ байгуулснаас хойш 21 хоногийн дотор гүйцэтгэх • Дундын тайлан- Гэрээ байгуулснаас хойш 90 хоногийн дотор гүйцэтгэх • Эцсийн тайлан- Гэрээ байгуулснаас хойш 120 хоногийн дотор гүйцэтгэх
6.2(б)	<p>Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: [120,000,000] /Нэг зуун хорин сая/</p> <p>Захиалагчийн хяналтын зардал / 1% / 1,200,000 /Нэг сая хоёр зуун мянга/</p>
6.4	<p>Төлбөр хийх данс: Худалдаа хөгжлийн банкны данс [423004295]</p> <p>Төлбөрийг дараах хуваарийн дагуу төлнө.</p> <p>(а) Гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх дүнг баталгаажсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн эхлэлийн тайланг ирүүлсэн тохиолдолд батлагдсан төсөвтэй уялдуулан төлнө.</p> <p>(б) Гэрээний үнийн дүнгийн 50 хувьтай тэнцэх дүнг гүйцэтгэгч дунд шатны ажлын тайланг гүйцэтгэсэн талаарх захиалагчийн хяналтын тайланг ирүүлсэн үед батлагдсан төсөвтэй уялдуулан төлнө.</p> <p>(в) Гэрээний үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх дүнг гүйцэтгэгч эцсийн шатны ажлын тайланг гүйцэтгэсэн талаарх захиалагчийн хяналтын тайланг ирүүлсэн үед батлагдсан төсөвтэй уялдуулан төлнө.</p>

	<p>Гүйцэтгэгч ГТН-ийн 2.3-д заасан тайлант үеийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд, гүйцэтгэгдээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05% алданги ногдуулна. Алдангийн нийт хувь гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.</p> <p>Чанарын баталгаат хугацаа нь 1 жил байх ба чанарын баталгаа нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна. Энэхүү баталгааг 1 жилийн хугацаанд гарсан зөрчил дутагдал, аливаа өөрчлөлтийг бүрэн шийдвэрлэсэн байдлаар дахин дүгнэж актыг үндэслэл чөлөөлнө.</p>
8.2	<p>Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүх, эсхүл дотоодын болон гадаадын арбитрын аль нэгэн байгууллагаар маргааныг шийдвэрлүүлэхээр сонгоно.</p>

3.7 АЖИЛЛАХ ХҮЧНИЙ АЖИЛЛАХ ХУВААРЬ

Д/д	Нэр	Албан тушаал	Тайлан гаргах /7 хоногээр/	Хуанлын хоногээр													Хувийн цаг			
				Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х	Х				
1	Г.Болормаа	Архитектор /зөвлөх/	1-ХVII																	
2	И.Г ончигбат	Архитектор /зөвлөх/	1-ХVII																	
3	Д.Богортуулгалаг	Барилгын инженер /мэргэшсэн/	1-ХVII																	
4	А.Очирбат	ЦБУ инженер /мэргэшсэн/	1-ХVII																	
5	Б.Болормаа	ХАС инженер /зөвлөх/	1-ХVII																	
6	Ж.Эрцэнбат	Цахилгааны инженер /зөвлөх/	1-ХVII																	
7	Т.Пүрэвзагд	ХД инженер /мэргэшсэн/	1-ХVII																	
8	О.Нарантуяа	Инженер геологич	1-ХVII																	
9	Г.Лэлэсүрэн	Төсөвчин /тэргүүлэх/	1-ХVII																	

Тайлангийн тоо: 8

Гүйцэтгэх хугацаа: Хуанлийн 120 хоног



"ЭМ ЭС ЭЛ" ХХК-ийн захирал

Г.Болормаа

3.8 АЖЛЫН ХУВААРЬ

А. Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгаа

Д/д	Үйл ажиллагаа /Ажлын нэр/	Зөвлөх үйлчилгээг гэрээ байгуулан эхэлсэн нэг дэх долоо хоногөөс																
		И	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	XIII	XIV	XV	XVI	
1	Судалгаа, шинжилгээ хийх /норм, дүрэм/																	
2	Эскиз зураг хийх																	
3	Эскиз зураг баглуулах																	
4	Ажлын зураг хийх																	
5	Ажлын зураг хувилаж хүлээлгэн өгөх																	

В. Ажлыг дуусгаж тайлан өгөх

Д/д	Тайлан	Зөвлөх үйлчилгээг гэрээ байгуулан эхэлсэн нэг дэх долоо хоногөөс																	
1	Эхлэлийн тайлан																		
2	Явцын тайлан																		
3	Хяналтын тайлан																		
4	Эцсийн тайлан																		

"ЭМ ЭС ЭЛ" ХХК-ийн захирал

Г.Болормаа



000029

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар... ЗТ17-337/19

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” Монгол Улсын хуулийг үндэслэн Улаанбаатар аймаг/нийслэлийн Сонгинохайрхан сум/дүүргийн “Эм Эс Эл” ХХК -Д

9011573077

/улсын бүртгэлийн дугаар/

6021026

/регистрийн дугаар/

ЗТ-2.1, ЗТ-3.1, ЗТ-3.4, ЗТ-3.5, ЗТ-4.1, ЗТ-4.5, ЗТ-5.5, ЗТ-6.1, ЗТ-6.2, ЗТ-6.3, ЗТ-6.4

ЗТ-7.1, ЗТ-7.2, ЗТ-7.3, ЗТ-7.4, ЗТ-8.1, ЗТ-9.2, ЗТ-11.1, ЗТ-11.2 заалтын дагуу

..... ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 03 -р сарын 15 -ны өдрөөс таван жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД



Х.БАДЕЛХАН

2019 он 03 сар 15 өдөр

Улаанбаатар хот

Ажил, үйлчилгээний төрөл:

- ЗТ-2.1** Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)
- ЗТ-3.1** Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)
- ЗТ-3.4** Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг
- ЗТ-3.5** Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг
- ЗТ-4.1** Архитектур, барилга бүтээц, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)
- ЗТ-4.5** Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг
- ЗТ-5.5** Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг
- ЗТ-6.1** Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
- ЗТ-6.2** Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
- ЗТ-6.3** Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл. Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл
- ЗТ-6.4** Барилга байгууламжийн дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл
- ЗТ-7.1** Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
- ЗТ-7.2** Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл
- ЗТ-7.3** Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл. Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл
- ЗТ-7.4** Барилга байгууламжийн дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл
- ЗТ-8.1** Орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилтийн зураг төсөл
- ЗТ-9.2** Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа
- ЗТ-11.1** Барилга байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, төсөв
- ЗТ-11.2** Барилга байгууламжийн ажлын төсөв

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг: СХД, 1-р хороолол, 17-р хороо, 33-11 тасгт

Компанийн захирал /эзэн/ Г.Болормаа

Утас: ...9903-1447..... Факс: И-мэйл:

Хууль зүйн сайдын 2016 оны
А.204 дүгээр тушаалаар батлав.



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000156124

2015.11.17

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011573077

/ Хувийн хэргийн дугаар /

6021026

/ Регистрийн дугаар /

Эм Эс Эл

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2015.11.16

/ он, сар, өдөр /

7110

/ код /

Барилгын зураг төсөл /2016.01.06-2019.01.06/

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

4610

Гадаад худалдаа

5621

Цайны газар

4799

Худалдааны зуучлал

4630

Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа

4330

Барилгын засвар хийх

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

10.0

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сонгинохайрхан, 17-р хороо, өнөр хороолол, 33, 11 тоот, Утас1: 99031447, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Гэрчилгээ дахин олгосон



Оюуны өмч, улсын бүртгэлийн
ерөнхий газар Хуулийн этгээдийн
бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

2017 он 11 сар 30 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Гунага овоотой Болормөө-а захирал-р томилсныг бүртгэв. Дэхйн гэрчилгээ олгов.	2017.11.30	О.Шижиртуяа
2		2017.11.30	О.Шижиртуяа
1	4330 Барилгын засвар хийх эрхлэх үйл ажиллагааг хассаныг бүртгэв.	2018.05.30	С.Мөнхсангир



Энэхүү гэрчилгээг үүсгэн байгуулагчид олгох үйл ажиллагааг хариуцаж үйлдсэн үйл ажиллагааны бүртгэл үндсэн дээр хийжээ.



СОЁЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

С.ОЮУНБИЛЭГ

2022 оны ... дүгээр сарын ... 8

БАТЛАВ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН

2022 оны ... дүгээр сарын

УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТРЫН БАРИЛГЫН ХҮЧИТГЭН ЗАСВАРЛАХ АЖЛЫН
ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2022 оны ... дүгээр сарын ... 08 № 2022/20 Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульШУТИС-ийн Технологийн их сургууль, Барилга архитектурын сургууль болон Оношлогоо, зураг төсөл, судалгааны "Реконстракшн" төвөөс гаргасан Улсын драмын эрдмийн театрын барилгын оношлогоо, 2022 оны 1сар
2	Барилгын байршил	Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Сөүлийн гудамж
3	Барилгын хүчин чадал	600 хүний суудалтай
4	Барилгын давхрын тоо	3 давхар
5	Барилгын үндсэн хийц	<ul style="list-style-type: none">- чулуут бетон шугаман суурь, төмөр бетон аяган суурь- багана дам нуруу бүхий каркасан холимог бүтээц- цутгамал төмөр бетон ба модон хучилт- 640 мм зузаан тоосгон даацын гадна хана- модон бүтээцтэй хамар хана- 2 давхар, шиллэгээтэй модон цонх- модон хаалга- ган татанга, модон шувуун нуруу- налуу дээвэр
6	Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал	Өндөр төвөгшилтэй барилга байгууламж
7	Газар хөдлөлтийн балл	8 балл
8	Гал тэсвэршилтийн ангилал	III зэрэг
9	Инженерийн хангамж	Төвийн шугамнаас хангагддаг Дулаан: Эзэлхүүн: 45403,2 м3 Зоорийн давхар: 538,5м2 Технологийн халуун ус: 162,78 ГДж/сар Цахилгаан: ТП-ны нэр: 260, Т-1, Т-II-ын 0.40кв-ын шиний эхний холбоос Сарын дундаж ачаалал: 30000 кв/цаг Усан хангамж: Цэвэр усны цагирагийн дугаар: 35 Бохир усны коллекторгүй Оруулга шугамын голч: 107мм Цэвэр усны ачаалал: 350м3 Бохир усны ачаалал: 350м3
10	Зургийн үе шат	Ажлын зураг, төсөв /Нэг үе шаттай/
11	Барилгын оношлогоо дүгнэлт хийх	<ul style="list-style-type: none">- Барилгын үндсэн бүтээц, суурь, дээвэр- Гадна ба дотор заслал, хана, шал, тааз, цонх, хаалга- Халаалт, агаар сэлгэлт- Ус хангамж, ариутгах татуурга- Цахилгаан хангамж

УЛСЫН ДРАМЫН ЭРДМИЙН ТЕАТРЫН БАРИЛГЫН ХҮЧИТГЭН ЗАСВАРЛАХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

		<ul style="list-style-type: none"> - Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар /БД 31-102-00/; - Барилгын төсөв зохиох дүрэм /БНБД 81-95-12/; - Барилга, байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/; - Түүх соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам /Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Дэд бүтцийн сайдын хамтарсан тушаал, №183/111, 2004.05.24
14	Захиалагч байгууллага	Соёлын яам, Улсын драмын эрдмийн театр
15	Хөрөнгө оруулалт	Улсын төсөв
16	Зураг төслийн байгууллага	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу шалгаруулна.
17	Зураг төслийн үнэ	Зураг төслийн ажлын жишиг үнэ /БД 81-16-20/ дагуу
18	Зураг төсөв боловсруулах хугацаа	2022 оны 2-р улирал
19	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - 2022 оны Төсвийн тухай хуульд XXIV.2.10 Улсын Драмын Эрдмийн Театрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/-ийн ажил тусгагдан, хэрэгжиж байгаа тул дээрх төсөл, арга хэмжээтэй уялдуулан зураг төсөв боловсруулах; - “Барилгад ашиглах материалын дээж, гарал үүслийн болон чанарын гэрчилгээг зохиогч, захиалагчтай зөвшөөрөлцсний үндсэн дээр барилгын материал татан авалтыг хийнэ” гэсэн заалтыг зурагт тусгах; - Халаалт, агаар сэлгэлтийн шугам хоолой нь MNS, ISO, EN, ISO-GOST олон улсын ба монгол улсын стандарт шаардлага хангаж байх; - Барилгын дулааны эрчим хүч хэмнэлт, үр ашгийг сайжруулах, найдвартай ажиллагааг хангах зорилгоор халаалт, агаар сэлгэлт, хөргөлтийн системийн тоног төхөөрөмжүүд автомат удирдлагатай байхаар төлөвлөх; - Барилгын дулаан хангамжийн дулааны болон гидравликийн тохируулгыг автоматаар хийхээр төлөвлөх; - Барилгын хийц болон хөрсөнд лабораторийн шинжилгээ хийх; - Барилгын оношлогоо, дүгнэлтэнд үндэслэн зургийн даалгаварт өөрчлөлт оруулах; - Ашиглагч байгууллагаас санал авах;

ТАНИЛЦСАН:

СОЁЛЫН ДЭД САЙД



М.БАТБАЯР


ЗӨВШӨӨРСӨН:

СОЁЛЫН ЯАМНЫ САНХҮҮ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА



Ж.ОТГОНБАТ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА



Э.ГАНХҮҮ